

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Насан овогтой Балдан- Ёндон	Дугаар	L110
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Өндөрхаан
Төрсөн газар	Хэрлэн сум	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Гүндгаварлин, Эрх ахайн Улаан Ганжуур	Сүм хийдийн дугаар	ХЭӨХ 059, ХЭӨХ 061
Одоогийн сүм хийд	Шадавдаржаалин	Сүм хийдийн дугаар	ХЭБВ 106
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Өндөрхаан сумын Гүндгаварлин, Эрх ахайн улаан ганжуурын хийд, Шадавдаржаалин хийд

-Таны шавилан сууж байсан хийд болохоор Эрх ахайн улаан ганжуур юм уу ?

Үгүй ээ, Эрх ахайн Улаан Ганжуур яах вэ, сүүлд сууж байсан юм. 6 настайдаа Цагаан эрэгний хийд, Гүндгаварлин хийдэд шавилан сууж байсан юм. Гүндгаварлин хийдийг чинь Цагаан эрэгний хийд гэдэг байсан юм.

-Та өөрийнхөө шавилан сууж байсан Цагаан эрэгний хийдийн тухай ярьж өгөхгүй юу? Хэдэн дугантай, хэр олон ламтай байсан тухай? Хурал номын хувьд ямар ямар хуралтай байсан бэ?

7 дацантай байсан.

-Хэр олон ламтай байсан бэ?

1000 гаруй ламтай байсан.

Хэзээ байгуулагдсан юм бэ?

1660 оны үед Шолой сэцэн хааны санаачлгаар байгуулагдсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

7 дацан нь юу юуны чиглэлээр байсан юм бэ?

Цогчэнтэй, Чойртой, Жүдтэй, Манбатай, Лхоготой, Дүйнхортой, Гүрмийн гээд 7 дацан дотроо байсан. Тэгээд 4 аймгийн дугантай. Нийтдээ 11 дугантай газар байсан. 4 аймаг 4-үүлээ дугантай байсан. Зүүн урд аймаг, зүүн хойд аймаг, баруун хойд аймаг, баруун урд аймаг гэж байсан. Тийм 11 дугантай 7 дацантай, 4 аймагтай газар байсан.

-Та 6 настайгаасаа хэдэн нас хүртлээ суусан бэ?

9 нас хүртлээ. 9 настайдаа Лха Жүсэм шүүлгээд тэгээд л гачигдлаар хөдөө гарсан. Хөдөө гараад хонь хариулангаа Эрх ахайн улаан ганжуурын хийдэд хурж байсан. Тийм л хүн дээ.

-Эрх ахайн улаан ганжуурт шунхан Ганжууртай байсан уу?

Шунхан Ганжууртай. Тэр бол Халхад ганцхан байсан. Уншаад үзэх юм бол Ганжууртай төсөөлөх юм юу ч байхгүй. Огт өөр ном байсан. Урьд ганжууртай газраас хүн ирээд уншиж байхад нь Ганжууртай газраас Ганжуур унших гэж ингэж хүний газар гүний нутагт орон гэргүй хүрч ирчихээд хүний юм гуйгаад гэж байхгүй юу. Өөрөө мэдэхгүй болохоор. Тэгсэн чинь битгий тэнэглээд бай. Энэ Ганжуур чинь бол Халхад ердөө ганц. Ганцхан гэх юм. Хаяагүй л Ганжуур байдаг биз дээ. Үгүй ээ. Үсэг нь өөр. Ном нь шал өөр юм гэж байсан юм. Хоорондоо хамаагүй шал өөр. Одоо энэ Улаан ганжуурыг уншаад бүгдийг мэддэг байвал нь газраар ч тэнгэрээр ч давхидаг юмны инженер ч болж чадна гэж Самдангончиг гуай хэлж байсан юм. Тэгэхлээр тэр ер нь их л учиртай ном байсан байлгүй гэж боддог юм. Би яахав бүгдийг нь уншаад л байна. Утгыг нь мэдэхгүй. Асуух дээр зэрэг тэгж хэлж байсан юм. Тийм шунхан Ганжуур байсан юм аа. Тэнд чинь Архангай, Өвөрхангайгаас хүртэл хүрч ирж Улаан Ганжуур уншуулж айлтгуулдаг байхыг би бага байхдаа мэднэ. Бүр холоос ирж байсан юм. Тэгэхдээрээ ховор байсан нь илт юм л даа.

-Гүндгаварлин хийдийн тухай эхлээд ярилцая?

Намайг байхад лам нь өвгөн хамба гэж хувилгаан багш байсан юм. Тэрнээс хойш хэнбугай ч хамба болох шахаа биз дээ. Тэгээд л дууссан.

-Гүндгаварлингийн хуучин гар зураг гэж байдаг уу?

Байж магадгүй. Хийдэд Гүндгаварлингийн зураг байдаг шиг санагдах юм. Байсан л юм л даа.

Гүндгаварлингийн гол шүтээн нь ямар шүтээн байсан бэ?

Хэдэн хэдэн шүтээнтэй. Голын 3 шүтээн гэвэл Цогчэн Жамсран сахиустай, Чойр нь Лхам сахиустай байсан. Жүд нь Янсан сахиустай ийм газар байсан. Тэгээд Дүйнхор байна. Манба байна. Ёга байна. Тийм л байсан л даа. Манбын дүлцэн, Дүйнхорын дүлцэн тавьдаг тийм л газар байсан. Ер нь том хийд байсан санадаг юм даа. Бага байсан болохоор.

-Хийдээс хутагт хувилгаад тодорч байсан уу? Ном зохиол бичиж байсан хүн байсан уу?

Тэрнийг мэдэх юм байхгүй. Хувилгаан хамба ном орчуулж байсан болохоос зохиож байгаагүй. Уул овооны тахилгын сангуудаа зохиож байсан байх л даа. Уул овооны тахилгыг барагтай хүн хийхгүй. Яахав сан, сэржим мэтийн номнуудыг даруулж авсан юмнууд байсан. Гүндгаварлин хийдэд нэг онцгой юм гэвэл Өөлдийн дайны

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

үед тэр дайнд оролцож явсан хүн энүүгээр дайраад урагшаа өнгөрөхөд энд айлд хоцроод тэгээд тэд нь ч тоолж мэддэггүй байсан юм уу, тэр бас жаахан зальтай ч лам байсан юм уу номтой хүн байсан юм билээ л дээ. Тэгээд энд нэлээн хөрөнгөтэй айлд хонь хариулаад үлдсэн. Хонь хариулж байж байгаа өдөр бүр орой болохлоор шанагыг нь авч гараад орж ирдэг. Гуулин ч юм уу, зэс ч юм уу шанагатай айл байсан. Тэгээд шанага нь өнгө ороод л байдаг. Тэгээд эр, эм хоёр ярьдаг байна л даа. Лам ч гэж мэдэхгүй. Хонийг нь хариулаад хоол өгөөд л байдаг байсан. Энэ хүн маань орой бүрий шанага авч гараад байх юм. Юу хийдэг юм бол гээд нээрээ наадахыг чинь үзье байз маргааш орой гэсэн. Тэгээд маргааш орой гарч ирэхээс нь өмнө хонин дотроо хэвтээд өгсөн. Тэгсэн нөгөөдөх чинь шанага барьж хүрч ирээд хотын зүүн урд хөлдүү хоргол байдаг. Тэрнээс барьж аваад дүнгэнээд л юм уншаад байх юм гэнэ. Тэрнийг нь сайн харж. Тэгээд гэрт орохоор хойноос нь ороод чи шанага аваад орой болгон гарах юм юу хийдэг юм бэ гээд асууж. За яахав ээ, би мандал өргөдөг юм. Надад будаа ч байхгүй, мандал ч байхгүй одоо яахав хонины хорголоор шанагаар чинь мандал өргөж байна гэж хэлж байна гэнэ. Тэгээд ярьж байгаад чи лам хүн юм уу гэхэд би лам би гэсэн. Лам хүн цэрэгт дайчлагдаад явж байсан. Чи ямар дацангийн юу хийдэг лам гэсэнд би Чойрын хүн гэсэн. Тэгсэн Чойр бол манайд байхгүй байсан. Манайд биш Халхад байхгүй байсан. Тэр өөлд хүн байсан. Тэгээд тэрнийг нь дуулчихаад хаандаа одоо нэг ийм лам байна гэж айлтгасанд тэгвэл явуулчих гэжээ. Тэгээд анхны чойр Гүндгаварлинд байгуулагдсан түүхтэй. Хоёрдахь нь Жанжин Чойр, гуравдахь нь Улаанбаатарт хурсан юм гэнэ лээ. Тэгэхээр Улаанбаатарт байгаа Чойр бол Гүндгаварлин хийдийн Чойроос дүү чойр болж байна.

-Гүндгаварлингийн мяндагтангуудын нэрийг дацан дацангаар нь хэлээч?

Хийдийн тэргүүн нь Хувилгаан хамба гэдэг хүн байсан. Цогчэнд лам байхгүй ловон гэж байна. Дацан хамба нараас Жүд хамба гэж байна. Чойр ламтай. Тэр нь шунлайв л байна. Их унзад бол голдуу л Цогчэндээ хурна. За тэгээд их хуралтай жилдээ бол бүтээл, том Хангал хүрж байсан. Цагаан сарын өмнө хуучин хурал хурдаг байсан. Манай эндэхийн байдал нь, тоног төхөөрөмж нь Гүнбүм дэгтэй газар байсан. Тийм учраас номын хувцас байнга хэрэглэдэг газар байсан.

-Өвөл ч гэсэн номын хувцастай байх уу?

Үгүй ээ. Модон шаамтай. Бусад газар байгаагүй ш тээ. Шашир л өмсдөг байсан. Аа энд бол модон шаамтай байсан. Төмөр бэрээтэй. Дотор нь жаяг хийсэн том. Сэцэн хан Хавлай ч юм уу тэрнээс хойш юм байх. Тэгээд одоо манай хийд Гүмбэн дэгтэй гээд Гүмбэн рүү морилж очсон юм байх. Тэгээд морилж очиход хийдийн захад горломын захад төмөр бэрээ барьсан гэсгүй модон шаамтай хүрч ирж угтсан. Энэ ер нь яасан юм, сэлэм шиг малгай өмсчихсөн, том төмөр бариад хурааж ав гэсэн юм байх. Тэгээд тэр чигтээ ингэж барьж бай гээд өгсөн юм гэсэн домогтой байдаг юм. Тэгж явж хүрч ирээд модон шаантаг төмөр бэрээтэй болчихсон юм гэсэн. Ийм л байсан юм л даа.

За Чойрын дуган нь бол голдоо байсан. Цогчин тусдаа. Чойр хамгийн их дацан том дугантай байсан. Тэнд Бүтээл, Ерөөл, Хангалууд бүх юм хурдаг. Гүрмийн дуганд бол одоо өдөр бүр 10 Хангал уншина. Жүд бол

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тусдаа. Гол том гүрэм бол Жүдэд л уншина. Жүдээс байж байгаад л сор гарч байна. Дүгжүү, догжир тийм мэтийн юмнууд Жүдээс л гардаг.

Бусад айлтгалууд нь дацангуудад байдаг л байсан.

-Чойр дацандаа ямар дом тавьдаг байсан бэ? Лхаарамбын дом тавьж байсан уу?

Мэдэхгүй ээ. Дом бол тавьж л байсан. Би өөрөө Чойрын биш болохлоор ёстой А ч байхгүй байна.

-Жүд, Манбадаа аграмба, маарамба болж байсан уу?

Аграмба болдог байсан. Жилд нэг хоёр лам болдог байсан байх. Аграмбын дамжаа барих, Тэр гуай аграмба болох гэж байгаа гээд бөөн яриа болдог байсан. Дамжаанууд байлгүй яахав. Тэр Чойрт юу үздэг тэнд л байсан байлгүй яахав.

-Та өөрөө аль дацанд хурдаг байсан бэ?

Би бол Цогчэнгээс гараагүй. Аль ч дацанд нь ороогүй.

-Ном барладаг байсан гэсэн. Яг өөрсдийн бартай байсан уу? Гүндгаварлингийн бар гэж тусдаа зүйл байсан уу?

Ном барлахын хувьд барладаг байсан. Аль газрыг барыг авчраад хийж байсныг мэдэхгүй. Учиргүй тусдаа юм байгаагүй байх аа.Ном бол барлаж байсан.

-Ямар ямар том ном судар барладаг байсан юм бол?

Мэдэхгүй. Гүндгаварлангийн ерөөлүүд магтаал дотор юм бий шүү.

-Сүүлд тэр хаагдаж нураагдахаас өмнө ямар нэгэн дуган сүм барьсан уу?

Үгүй. Нэмэгдээгүй.Ердөө л хуучнаараа байсан. 1953 он хүртэл их дуган байсан. Наана нь жижгүүд нь нурсан байсан.Их дуган нь хоёр давхар байсан. Их дуган бол байсан. Орос цэргүүд дуган дотор байрлаж байсан.Архи уугаад л.

-Гүндгаварлин хийдийн хурал номын үйл ажиллагааны тухай?

Одоо ямар хурал гэх вэ. Чойр бол чойроо л хурна. Цогчэн бол цогчэнгээ л хурна.Жүд бол яахав. Өөрийнхөө аргынхаа юмыг хурж байна. Тэгээд Дүйнхорт дацангуудаас очиж хурдаг. Манба бол тусдаа бие даасан байсан.Ёга яах вэ. Ийм л байсан. Цагийн хурал учиргүй их. Юу юу ч байлаа. Энд хайлан л хийдэггүй байсан.

-Хайлан хийдэггүй байсан юм уу?

Хайланг Улаанбаатарт очиж хурдаг байсан.

-Цам гардаг байсан биз дээ?

Цам яахав хоёр янзын цам гардаг байсан. Дарь Эхийн цам, Цэрэндүгийн цам хоёул 1 өдөр гардаг байсан. Чогар цам, Цэрэндүгийн цам хоёр. Майдар эргэнэ.

-Цамын нийт хэдэн дүр гарах вэ?

21 Дарь Эх, Цагаан өвгөн байна. Хашин хаан байна. Азар байна. Шувуу байна. Буга, Согоо байна.Ийм юмнууд гарч байсан юм. Цэрэндүгийн цам бол бүр их гоё, шувуу нь хачин сайхан. Цартай будааг зуугаад аваад явна. Дотроосоо өөрөө амыг нь онгойлгоод. Гоё цам байсан. Нэлээн хүнд. Бүх биеийг нь төмөрлөсөн байсан.

-Хэдийнээс цам гардаг болсон юм бол оо?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Байгуулагдсанаас нэлээн хойно гараа биз дээ. Тэрнийг бол төдийд өдийд гэж хэлэх юм байхгүй. Цамд би гарч байгаагүй. Цагаан өвгөний хоёр хүүхэд байсан. Тэрнийг дагаж гарч байсан. Өөр юманд гарч үзээгүй.

-Цам нь хэдүйд гарахаа больсон юм бэ?

Үгүй яахав тухайн үедээ 30 хэдэн оны үед л байх.

-Майдар хэдүйд эргэдэг байсан бэ?

Майдар бүтээл төгсөөд эргэнэ. Одоо ч тэр журмаар явж байгаа.Ерөөлийн хурал гэж хүрээнээс өөр хурал байсан. Хүрээ бол Чойнпрул жона уншина. Энд Цац молон уншдаг. 22-нд гүйлгээгээ уншаад 23-нд сахиусаа тахиад тэгээд Ерөөл төгсөөд тоглодог байсан.Хурц ламынх болохдоор Чойнпрул жона, манайх Цац молонмоо хурна. Цац молон гэдэг нь Гүмбэний л юм байгаа.

-Майдар эргэхэд цам гардаг байсан уу?

Өглөө нь Майдараа эргээд маргааш цамаа гаргана. Майдар цам гэдэг чинь хоёр өдөр дараагаар л гарна.

-Ганжуур эргэх ёслолын тухай? Нутгийн хилийн дээсээр эргэдэг байсан уу?

Хошуугаа Эрх Ахайн Улаан ганжуураар эргэнэ. Гүндгаварлингаас биш Эрх Ахайн Улаан ганжуураас эргэдэг байсан. Гүндгаварлины зүүн хойд хүрээний хийд. Зун ерөөлөө хурна. Дан зүүн хойд хүрээнийхэн ирнэ. Улаан ганжуурыг Өндөр гэгээн залж ирсэн гэдэг юм. Гүний шүтээн манайтай холбоотой байсан юм. Эрх ахайн улаан Ганжуур бусад ганжуураас шал өөр байсан. Дүнгсоном гавж гэдэг хүн очиж айлын гэр гуйгаад тэнд Улаан Ганжуурыг тоолохгүй юу. Тэгээд би тэнд байж байсан барагтай залуу лам байсан л даа. Та одоо Ганжууртай газраас Ганжуур тоолно гэж энд ирдэг нь юу юм гэсэн чинь чи битгий тэнэглээд бай наад Ганжуур чинь Халхад ганц байдаг Ганжуур гэсэн. Тэр яахав дээ. Үсэг нь Ганжуур л бол Ганжуур байдаг юм байгаа биз дээ гэсэн. Үгүй ээ, үгүй. Тэр Ганжууртай чинь ердөө нэг нийлэх юм байхгүй. Шал өөр ном байхгүй юу гэж надад хэлж байсан. Тэгэхдээрээ тэр ховорхон Ганжуур байсан байх аа. Суварганы хийдийг Өндөр Гэгээний шавь нь ч юм уу, юу нь ч юм хожуухан явж бий болгосон гэсэн.Хэрлэнбаяны арцыг Өндөр гэгээн аравнайсан гэж ярьдаг юм. Домог л доо.

-Ганжуур эргэхдээ Сэцэн ханыхаа аль аль хошууг тойрдог байсан бэ? Ганжуурын хийдийг босгоход Сэцэн хаантай хамаатай нэг түшмэдийн авгай Эрх Ахай гэж байсан. Түүний буянд зориулж хийд бий болгосон. Үүний нэлээн сүүлд Улаан Ганжуур ирж Эрх Ахайн Улаан Ганжуур гэдэг нэртэй болсон гэдэг юм. Тэгээд тэнд чинь уламжилсан тайж гэж байдаг даа.Тэд нар л нэг нь үхээд л нөгөө нь уламжилж гараад л тэгээд нэг тайж хариуцаж байдаг байсан юм. Хариуцаад хийдэг юм ч гэж байгаагүй. Нэртэй л байдаг байсан. Улаан Ганжуур хошуу эргэдэг байсан тул 10 хэдэн ширмэл ууттай байсан. Тэгээд тэрэнд хийгээд тэмээнд ачаад тэмээний өвдөг хөл нь харагдаж байна. Их том шар юмаар бүтээчихсэн. Бөх нь ил, тийм хэдэн тэмээтэй ачаад гараад явдаг байсан.Тэгээд л одоо Сэцэн хан аймгийнхаа Хааны хошууг эргэдэг байсан.Гүний шүтээн 7 хоног аваачиж хурдаг байсан. Ганжууртай, Данжууртай, Улаан юмтай байсан. Ганжуур 108 боть, Данжууртай 240 боть, Улаан юм 25 боть байсан. Дуган дотор ердөө ийм гурван ном л байна. Хойно нь шүтээнийх гээд нарийхан шавар туйпуун барилга байсан. Тэрний чинь нэлээн урдхан дуганын буурь байгаа. Дөв дөрвөлжин.Тэгээд тэр

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

шүтээний чинь дуганын дотор бүх бурханууд байсан. Эрх Ахайн Улаан Ганжуур Гомбо сахиустай Байнгын хурал байхгүй. Цогчэн энэ тэр байхгүй ш тээ. Шинийн 8, 15, битүүн энэ гуравт л Ганжуураа ч уншина, Данжуураа ч уншина, Улаан юмаа ч уншина. Мөн Хангалаа 3 хуваагаад тахина. Ийм хурал байсан юм.

-Хааны хошуугаар Ганжуур эргэхдээ хаагуур явдаг байсан бэ?

Эндээсээ урагшаа гараад Баянхутаг ороод тэгээд энэ урдуур Цайдмаас хойгуур ингэж яваад Хэрээ, Гөхөл ороогоод гардаг байх аа. Би дагаж яваагүй. Жаахан байсан. Ганжуур эргэнэ гэдэг маань Ганжуураа авч явж эргэнэ шүү дээ. Нэг буудлаас нөгөө буудалд хүртэл хоорондоо Жамбал Цанжид, Дэмбэрэл Догва байнга уншиж явдаг байсан. Тэр хооронд л уншаад явдаг. Тэгж эргэж байсан юм гэдэг. Сүүлд нь манайх Ганжуур эргэхдээ машинд суучихаад уншиж явсан. (1990 оны дараа)

-Нүгнээ зэрэг шашны үйл ажиллагаа байсан талаар? Гүндгаварлин хийгээд Эрх Ахайн Улаан Ганжуур хийдэд?

Гүндгаварлинд ч байсан л байх. Эрх Ахайн Улаан Ганжуурт байсан. Зөндөө. Нүгнээ бол Ганжуур тэр хавийн айлуудад дэлгэрчихсэн ном байсан. Буянч айлууд цагаан сарын дараа манайх нүгнээ сахиулна гээд л лам нарыг гуйгаад тэгээд чавганц нар ч хамаагүй суугаад тахидаг. Ер нь нэлээн дэлгэрэнгүй буяны хурал болсон байсан. Тэгж байдаг байсан юм аа.

-Шашны зан үйлийн дараа наадам хийдэг тийм зүйл байсан уу?

Наадам хийдэг юм байхгүй. Ердөө хийж байгаагүй. Байх ч үгүй дээ ер нь . Харин ерөөл төгсөөд хүүхдүүдээ тоглуулдаг байсан. Ерөөл төгсөхтэй зэрэг л тоглоомд гарна. Хушга харвана. Хушга таана. Томууд нь мань мэтийг хуураад л хамаг хушгийг маань авчихна даа. Багшаас хушгаа аваад 7 хоног хүргэх гэж их мэрийнэ. Тэгээд хэрэг байхгүй. Аваад л гарахаар том хүүхэд за хушга таах уу жаал аа гэнэ. Тэлье гэхдээр дор нь л аваад явчихна. Тэгээд хамаг хушгаа алдчихаад. Хийдийн жижиг уншлагатай болсон Цогчэнгийн жижиг хүүхдүүд Цогчэн уншина даа. Тэгээд л тэр 7 хоногт чинь зарим нэг нь өөртөө таарах жанч олоод зарим нь дээлээ жанч гээд нөмөрчихнө, зарим нь дээлийнхээ ард юм унжуулчихаад хурал хурна шүү дээ. Цогчэн л уншиж байсан биз дээ, бодвол. Тэгээд одоо дуулалдана гэж. Жасаас манз барьдаг байсан. За тэгээд хоёр нэгэн манзтай тэгж сууж байгаад тарна даа. Тэгээд их зантай тарна аа. Тэнд чинь лам ч байна, шунлайв ч байна, гэсгүй ч байна. Байдаг юмнуудыг бүгдийг нь томилочихно. Тэгээд тэднүүд чинь маадгар. Иймэрхүү маягтай л юм тоглодог байсан даа. Тоглоом гэдэг маань ерөөлийг дараа тийм зүйл болж байлаа.

- 7 хоног тоглох уу?

7 хоног тоглодог байсан. Жижиг хүүхэд хурал хүрж тоглож байгаа хэрэг л дээ. Тэгээд тэрнийг маань тоглоом гэхгүй Их жасаас хоёр нэгэн манз авчирч өгдөг байсан. Цав олодохгүй ээ. Манз уучихаад хадаана аа. Том лам нараас ердөө орж ирэхгүй. Хүүхдүүд одоо айна ч гэдэг юм уу. Ердөө үзэгдэхгүй ш тээ. Чонбо л за та нар сахилгагүйтэв ээ гэдэг байсан. Тоож байгаа ч юм байхгүй. Тэгж хүрж байсан юм. Жилдээ ганц 7 хоног л тоглоом байдаг.

-Өдөр тутмын уншлага, зан үйлийн тухай?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цогчэнгууд ер нь тус бүрдээ л өөр. Том ерөөл маань хуваарьтай байдаг. Тэр бол газар сайгүй байсан байж магадгүй. Хангал бол харин ижилхэн байсан. Хангалын ян гэдэг маань бол хийд хийд дээр хийж байгаагүй. Би Эрх Ахайн Улаан Ганжуурт бага унзад байсан. Зүүн хойд чигийнхэн Ганжуураа л нэг задлуулъя гэдэг. Авгай нар морио бүдэрсэн ч Махгал гэж бархирч байдаг. Махгал шүтээний байсан учраас.

-Гүндгаварлин хийдийн барилга нь ямар материалаар баригдсан байсан бэ? Дуганууд нь ямар хийцийнх байсан бэ?

Төвд маягийн дуганууд байсан. Тэнд чинь Цогчэн дуган туйпуун дуган байсан. Их дуган маань модон дуган байсан. Жүд туйпуун дуган байсан. Дүйнхор дүнзэн байшин байсан. Ёга бол банзан дуган байсан. Гүрэм бол яахав дээ, шавраар барьсан жижигхэн дуган байсан. Тэгээд өвөл болохлоор утаа тавиад л суудаг байсан. Бусад дуган нь гал хөс гэж юм байхгүй ш тээ. Миний хүрж байх үед галтай дуган гэж байгаагүй. Эрх Ахайн Улаан Ганжуур дээр хөөргөнд хийдэг нүүрс авчирч байдаг. Тэрнийг аваачаад тогоонд голд нь асаагаад тавьчихна. За голд байгаа лам нар нь гайгүй. Шуурга шуурахад цас орж ирдэг банзан дугантай байсан.Тийм юм чинь яаж дулаан байх вэ? Мичид тонгойход л өвөл өглөө хурал эхлэнэ. Бүрээ дуугарна. Тэгээд л ороод орой харанхуй гарч ирнэ. Бардаа гэвэл Дамдингаас 1 юм аялачихаад , тэгээд Магтаалаас нэг юм аялачихаад ердөө ийм гурван юмаар бардаална. Хуучин гэвэл нэгэнт тодорхой. Шинэ Ганшиг Хангал ч их аятай байсан.Тийм л гурван янз байлаа даа. Манай энүүгээр л лав.Ерөөлд бол манай энд 11 маани татаж байсан.Хамгийн том нь Норовбадам.Тэгээд манай энд чинь Лхас гэдэг маани их татдаг байсан. Миний нэг шавь хэдэн жилийн өмнө Улаанбаатарт унзад нарын шалгалт шүүлэг болсон юм. Тэнд Лхас татан өгч хачин гайхаж байсан гэдэг. Хөнгөн мөртлөө ямар гоё аятай аятайхан маань вэ гээд. Манайх бол яахав. Тэр татдаггүй газартаа тэгж байхгүй юу. Миний хэдэн шавь нар бүгд татна. Энэ маанийг чинь энд тэнд явж байгаад татаж болохоо байсан юм байна. Маани татахгүй газар байх юм. Би Эрдэнэтээр явж байхад хуралд нь тэгж таарсан. Маани байхгүй, цоглом байхгүй байх юм. Тэгээд одоо маани татдаггүй юм уу гээд асуусан. Мэдэхгүй ээ манай энэ хууччуул маань бидэнд юм хэлээгүй ш тээ л гэж байсан. Манай хийдээс 6 хүн 2005 онд Баян-Овоод очиж Оройн ерөөл хураад цогломд хоёр хүн босоод тэгээд маани татаад сайхан боллоо. Тэгсэн чинь Чүлтэм гэдэг хүн хүрч ирээд дэргэд суучихлаа. За хө би энэний урьд одоогоос 2 жилийн урьд Гандан хавьд нэг ерөөлд суусан. Ердөө маани мэдэгдээгүй.Би уг нь урьд хийдэд бараадаж байхдаа Оройн Ерөөл хурахад маани татаж, цоглом босдог гэж ойлгож байсан. Тэгсэн одоо энэ байхгүй болсон юм байлгүй дээ гэж бодож байсан. Тэгсэн та нар зургуулхнаа ерөөл гэдгийг бүтэн унших шиг боллоо гэж хэлсэн.Тэр хүн өөрөө номтой хүн байсан. Бид ямар юмаа тийм шүүгч сууж байгаа гэдгийг мэдэх вэ.Тэгэхдээ бид шүүлгэж муу юм болоогүй. Тэр сүрхий хүн байсан.Гадуур явж юм уншина гэдэг бол хэцүү шүү. Ерөөлийг хорь гаран өдөр хурна.

-Битүүнд Цэдор Лхамаа хурчихаад яах вэ?

Цэдор Лхамаа хуралгүй яах вэ. Тэгээд дарга нар ирж шинэлдэг. Энэ маань хуучин ч байсан шүү дээ. Өглөө яахав хурал тарах гэж байдаг. Тэгээд Мандал өргөдөг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Төвдийн болоод Монголын ямар хийдүүдтэй холбоотой байсан бэ? Гүндгаравлин Гүмбэнтэй холбоотой.Амьтан хүн явдаг очдог. Мөргөдөг. Гүмбэнгээс ч лам нар ирдэг байсан. Манай энд Өндөрхаан ганшигтай. Алтан овоо ганшигтай ердөө Хангал. Хангалтай холиод уншихад болно. Ондог бол ондог байна. Замлин бол замлин байна. Ганшигийг Төвдөөс зохиосон. Алтан овоог Лхас хүртэл тахиж байсан юм. Манай Өндөрхааны ганшиг ч гэсэн бий болохдоо мөн түүхтэй. Эрэвгэр сэцэн хаан гэдэг 20 настай жасаалахад хаана ч юм энэ бүтэхгүй хүн байна. Энийг хороохгүй бол Монголд манайх сууж чадахгүй нь гээд гэж баранд бариулах гэж уул руу бар алуулахаар явуулсан. Тэгээд бар алах гэж яваад баранд гарцаагүй бариулах байсан. Тэгсэн Өндөрхаан уул аварсан. Тэгээд миний л уул намайг аварлаа гээд Лхаст очиж Далай багштай уулзаж Өндөрхааны ганшигийг зохиолгож байсан хүн.

-Гүндгаварлингийн жасын тухай?

Цогчэн жас, Их жас, Жүдийн жас гэсэн гурван жас байсан. Хамгийн том нь Их жас байсан. Том хурал хурдаг байсан газрын жас. Цогчэнд том хүн бараг хурахгүй хүүхэд эрхлэхэд хайхардаггүй.Нэг айлын гал тогооноос илүүдэх юмгүй байсан байх аа. Миний байж байхад Хайдав унзад гэж унзад байсан. Том хүн бараг хурахгүй. Хүрч ирээд л уншаад гарна. Харин уншихгүй хүүхдийг босгочихоод байдаг байсан.Тэгсэн мөртлөө эрхлээд байхад нь үг хэлдэггүй тийм хүн байсан юм.Одоо багана руугаа дээшээ өгсөөд байдаг байсан. Тэгж байхад уншаад л сууж байна. Хүүхэд эрхлэхэд сууж л байдаг. Цогчэнгийн шилгүй гүнгэрваанд баримал Жамсран байсан. Түүний хамар амаар нь их тоглодог байсан.Цогчэнгийн хүүхэд гэж эрх, задгайдуу, танхай хүүхэд л байдаг байсан. Тэгэхэд Хайдав унзад гуай үг дуугарахгүй. Уншихгүй байна л гэж хэлнэ. Уншиж л байвал болдог. Цогчин гэсгүй маань хамгийн том гэсгүй шүү дээ. Тэр олон гэсгүйнүүдийн хамгийн том нь. Тэгээд л Хүрээний гэсгүй орж ирээд зандарна. Үгэнд орохгүй дээ. Сурчихсан юм. Цав манж барих хооронд баганын хоорондуур гүйлдээд л нэгийгээ бархируулаад дарж унагаад л үймүүлдэг байсан. Хөөе, манзандаа суугаарай гээд л учиргүй их загнадаггүй байсан. Жас бол тийм гурван жас л байсан. Жасын хөрөнгө ямар юм байсныг яаж мэдэх вэ.

-Гүндгаварлин хийдийн лам нарын сууц хаанаа ямархуу байдалтай байдаг байсан бэ?

4 аймагт хуваагдаад аймаг аймгаараа хүрээгээ тойроод л байсан. Аймгийн лам байна. Аймгийн унзад байна. Аймгийн гэсгүй байна. Хурлын завсарлагаар аймагтаа хурна.

-Хийдэд хандмаа нар байсан уу?

Байхгүй. Ер нь лүйжин тавьдаг хүн бараг байгаагүй.

-Жодын хурал байсан уу?

Жодын хурал хойшоогоо л байна. Хүүхэн хутагтын хийд байна. Бэрээвэн хийд байна. Бид том дамартай хүн хараад маш их сонирхдог байсан. Өөрсддөө байхгүй болохоор. Манай энд бол бараг байгаагүй. Харин чойжин байсан. Дээр үед Даваа чойжин гэж байсан.

-Чойжинг хошуу ноён буулгах уу?

Тийм. Уул нь хар хүн байсан. Хошуу ноён урагшаа Лхасад явсан юм уу даа. Тэгэхэд хоол ундыг нь бэлдэж өгдөг Даваа гэдэг хар хүн байсан. Тэгээд тэр очоод тэнд горломын гадаа буучихсан байсан. Халхын нэг том хаан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ирсэн гээд олон хүн цуглачихсан байсан байна. Нэг өвгөн хамба байсан юм гэнэ лээ. Тэгээд тэр хамба очсон. Даваа гүйж явж байгаад Найчин гэдэг дацан байсан байгаа юм. Тэр дацангийнх өмнө нь шээж байсан юм байх. Тэгсэн ар дээр нь нэг юм тог хийтэл нэг очир хаячихаад явчихсан байсан. Тэгэхлээр нь аваад өвөртөлчихсөн. Лам нар, хар хүмүүс тусдаа байртай байсан. Тэгээд орой хувцсаа тайлтал өврөөс нь очир уначихсан. За чи чинь очир хүлгэй хийгээд явна уу гэж наадүүл нь доог хийсэн. Найчингийн хэдэн хүүхэд очроор чулуудсан байсан. Тэгэхдээр нь аваад өвөртөлчихсөн юм. Мартчихсан байж л дээ гэсэн. Тэгсэн чинь цаадуул нь хамбад хэлсэн. Лам айсан. Ер нь одоо юу болох бол гээд. Найчнгийн дуганын өмнө шээж байдаг. Найчин Чойжоо л тэр байх гээд. Ингээд асууж сураад одоо ер нь Чойжин буулгахгүй бол болохгүй гэж. Даваа 2 хоноод ухаан алдаж унадаг болсон. Тэгээд Найчин Чойжин торонд буудаг байсан. Торон дотор нь оруулчихсан. Цамнаад л байсан. Цаадах нь барьж аваад дээр нь гишгэчихээд. Тэгээд сэлмээ сугалаад ам хамар луу нь дүрээд байсан. Одоо энэ алуулчихаж байгаа юм биш байгаа гээд харж л байсан. Тэгсэн чинь цагаан хөөс сахарчихсан босоод ирсэн. Тэгээд л Чойжин болсон. Тэр Чойжин бол агуу чойжин байсан. Тэгээд Даваа Чойжин лам болсон. Уншлага байхгүй шахуу хүн байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр мөн гэртээ ганцаараа суудаг байсан. Хөдөө хар байсан болохлоор хамт наргиж тоглож байсан нөхдүүд нь ирдэг. Тэгээд буудаг гэнэ. Буухлаараа за данхаар ус аваад ир, хоёулаа сайхан цай чанаж ууя гэдэг байсан гэсэн. Тэгсэн ганцаараа усаа ч авахгүй суудаг байсан байгаа юм даа. Тэгсэн нөгөө хүн чиний усыг зөөх гэж ирсэн юм уу, солиор гэж загнаад байсан. За чи аваад ир л дээ гэсэн. Чадахгүй гээд гүйж очоод мориндоо мордохоор морь нь булгаад хаячихсан. Хоёр мордоод, хоёр ойчоод хөөе Даваа чи данхаа аваад ир гэж байсан гэсэн. Усанд нь явж өгөхгүй гээд явуулахгүй байхгүй юу. Дүрсгүй хүн байсан. Сайн Чойжин байсан юм гэнэ лээ. Би хошуу эргээд бууж явахад нь Эрх Ахайн Улаан Ганжуур дээр нэг харсан. Өвгөжөөр хүн байсан. Жамсрангийн үүднээс л бууна. Найчин, Жамсран хоёроор буудаг хүн байсан юм гэнэ лээ. Чулуун чойжин гэдэг ч Жамсрангийн үүднээс бууж байсан. Бэрээвэнгийн Дамдин гэдэг чойжин ч Жамсрангийн үүднээс бууж байсан.

-Ер нь Чойжин Жамсрангийн үүднээс их байсан юм уу даа?

Тийм. Жамсран чинь Чойжингуудын зарц юм чинь. Цаадахыгаа л явуулдаг л байлгүй. Гомбо энэ тэр бол хүн дээр чинь очно гэж ярихгүй ш тээ. Их зантай амьтад ярихгүй. Жамсран яахав. За яв гээд би нэг шавиа хэлж байгаа юм шиг. Би ч одоо дээр үед Дамдин чойжин гэдгийг бууж байхад бага байсан. Тэгэхдээ 13-тай байсан. Ер нь Чойжин хүн гэдгийг таашаадаггүй байлаа. Буухыг нь харахад дээр нь алт хөвсөн архи уучихаад алтаа долоочихоод тэгээд л одоо очоод суучихдаг. Бараг галзуурдаг байх даа. Тэгж боддог байсан. Тэгээд тэр Дамдин чойжин гэдэг хүнийг айлд ирээд байхад нь Найчингийн жанан тавихад би бас сахиусанд нь оролцсон юм аа. Тэгээд Мэгзэмийн жанан хурахдээр очоод суусан гар гэсэн. Ер нь гэрт байхад хэлж байсан. Мэгзэмийн жананг суулгахгүй гэж. Суулгахгүй гээд одоо харанхуй гэр дотор гэж бодоод. Том гэр дотор олон чавганц хүүхнүүд суучихсан байхгүй юу. Тэгээд гутлаа тайлаад чавганц нар дотор суучихсан. Яаж байгаа юм лам хүн байж гээд хөөгөөд байхаар нь дуугүй бай Чойжин намайг суулгахгүй гээд байгаа юм. Дуугүй дуугүй би энд суучихъя гээд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

суучихсан. Тэгсэн харж байснаа хөөе Балдан-Ёндон гар суулгахгүй шүү чамайг хэлээд байхад гэнэ. Тэгэхээр нь гутлаа өмсчихөөд гараад явсан. Тэгээд мордоод гэрээдээ явж байхдаа өө ямар олдохгүй оюу эрдэнэ биш дээ Найчингийн жанан тавих хүн хаа мундах вэ гэж бодож явсан шүү. Тэгээд хэд хоносны дараагаар Чойжин бууна гэж. Тэгсэн нэг хүн хүрч ирээд өөрийг чинь хүрээд ир гэж байна гэсэн. Өнөө Дамдин чойжин ирсэн гэнэ. Яваад очлоо. За одоо жодва байхгүй ирсэн үү, жодва ч яахав гэж байна. Өө яаж мэдэх юм. Би ердөө сууж үзээгүй юм чинь. Түрүүн л таны сахиусан дээр орж дэргэд нь бараа болж байгаад явсан. Мэдэхгүй юм чинь гэсэн. Тэгсэн чинь болноо болно. Би сахиусанд айлтгачихсан гэсэн. Тэгээд л одоо Жамсран уншлаа. Жамсран уншихдаа жандаглаад хурахдээр тэр хувцсанд их учир байгаа юм. Хувцсаа ингээд өөрөөр тавьж байгаа юм. Хураагаад өмсөхөд л бэлдэж байгаа юм. Тэрнийгээ өмсөхгүй бол буухгүй л дээ. Тэгээд түрүүнд нь буухад хүн очоод чихэнд нь хэлдэг. Асуусан юмыг нь. Баруун суганд нь очоод толгойгоо хийгээд тэгээд хүрч ирээд сайн гэж байна тийм гэж байна гээд юм хэлээд л байх. Чойжин маань хэлж байгаа бол уу даа, наадах хүн л хэлж байгаа байх гэсэн шүүхэн юм бодогдоод. Тэгсэн тэрнийг маань мэдээд жодва хийлгэсэн ч юм уу яасан юм. Хэлж байна аа. Ном авах, сэлэм сугалах ийм асуудлыг хийх юм бол хорино шүү. Байг гээд загнаарай. Үгэнд орно. Би чамайг шавьд оруулаагүйн учир энэ. Ер нь шавь хүн хийж болдоггүй юм. Тийм учраас чамайг би суулгахгүй гэсэн юм гэсэн. Тэгээд одоо сэлэм сугалах гэвэл загнаарай. Аврал асуухаар чихэнд хэлээд тэгээд дамжуулдаг юм. За одоо энийг чинь сонсдог хэрэг гээд чихэнд нь хэлчихээд суганд нь толгойгоо хийхээр яг л тэр хүний үг. Гэхдээ сайн дуугарахгүй. Бараг шивнэх шахуу маягаар хэлж байсан. Тэгээд л Чойжин хүн чинь учиртай юм байна гэж боддог болсон. Нээрээ учиртай байдаг юм байна лээ. Гүндгаварлин дээр Чулууны Чойжин, Өвөөний Чойжин гэж байсан. Тэр Өвөөний Чойжинг их шоолдог байсан.

-Гүндгаравлингийн лам хуврагийн өдөр тутмын амьдрал сүсэгтнүүдтэй ямар харилцаатай байсан тухай ярьж өгөөч?

Нэлээн хүндтэй хийд байсан юм аа. Ер нь одоо 1000-аад ламтай байсан гэхэд 300, 400-аад шахуу өрх байсан. Хар цай уудаг айл байгаагүй байх. Тэгээд л бодоход нэлээн хүндтэй байсан байлгүй. Ер нь ч их сайхан онцлогтой газар байсан. Цагаан эрэгний хийд гээд маш сайхан уншлагатай газар байсан. Чойртоо бол гүн ухааны хүмүүс нь явж байсан юм байгаа биз. Уншлагандаа бүх лам нар нь голлодог хийд байсан. Маш их сайхан уншлагатай.

-Лам нарын өдөр тутмын амьдрал ямархуу байсан бол? Жасын тухай?

Жасын мал айл айлд байсан. Эрх Ахай дээр ч жасын малыг айл айл харна. Манайх бол харж л байсан. Хоёр сэтэртэй хар хоньтой тийм суурь хонь манайх хардаг байсан.

-Та хэдэн настай хар болсон бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Есөн настай хар болсон. Гүндгаварлингаас гараад хонь хариулж байсан. Хонь хариулж байхдаа Хангалаа үзчихсэн. Тэгээд л очоод уншаад. Тэгээд өөрийгөө магтаж байгаа юм биш уншлага сайтай байсан. Тэгээд хөдөөний газар чинь номоо дэлгээд уншдаг лам нар байсан. Тэгэхлээр би бол цээжээр уншдаг байсан. Ээжтэйгээ хамт хонь хариулаад байж байсан. Тэгсэн манай хүргэн ах за хонио хэдэн үхэртэйгээ манайд өг ерөөсөө хүмүүс Балдан-Ёндонг уншлагатай гээд сайн хэлж байна. Одоо энийг зэврүүлээд яахав. Тэнд сүү. Энэ мал ахуй чинь над дээр байж байг. 1000-аад хонин дотор танай хэдэн 100 хонь ороод тэр дотроос үхэх гэж байхгүй. Байгаагаараа л байна. Би тэрнээс хороохгүй гэсэн. Манай эх хүү минь хүүгээ бодохоор тэгмээр л байна. Тэгтэл одоо хар цай ууна гэдэг мөн хэцүү гэсэн. Тэгсэн хүргэн ах та нар ерөөсөө нэг ч хар цай уухгүй. Зун ааруул тавина гэж бодоорой гэж хэлээд тэгээд л үгэнд нь ороод Эрх Ахайн Улаан ганжуур дээр очиж буусан. Тэндээс л лам гэдгээ зогсоосон.

-Гүндгаварлин хийд хэдэн онд хаагдсан юм бэ?

Энэ одоо мэдэхгүй хэдэн онд хаагдсан юм бол. 1937 онд л хаагдсан байх. Надтай Цогчэнд хурж байсан Лувсаннамжил гэдэг хүн хамгийн сүүлд хааж гарсан.

-Хийдийг хаах тушаалыг хэн өгсөн? Хаагдсны дараа лам хуврагууд юу хийдэг болсон? Дугануудыг хэзээ нураасан гээд тэр тухай санаж байгаа зүйл байвал хэлээч?

Өө ямар юм байхав. Эрх Ахайг бол яахав 36, 37 оны үед хаагаад лацадчихсан. Тэгээд цоожтой байж байгаад баларсан. Нураагаад аваад явсан. Гүндгаварлинд бол гол дуган нь үлдчихсэн байсан.

- Гүндгаварлингийн ном судар, шүтээнээс үлдсэн юм байгаа юу?

Нэг Жамсран байсан. Гэхдээ миний уншиж байсан биш л байсан.

-Одоо тэр нь байгаа юу?

Байхгүй. Хулгай авчихсан. Энд чинь одоо хоёр дахин хулгай орж байна.

-Хийд хаагдаад хар болсны дараа та юу хийж байсан бэ?

Би 18-тай хар болсон. 21-тэй цэрэгт явсан.Цэргийн алба 5 жил хаасан. Тэгээд л ажил хийсэн. Гол ажил жолооч. Тэгээд 1990 онд хийд байгуулахад намайг лам бол гээд чадахгүй байх гээд байсан. Тэгээд 1991 онд эргээд лам болсон.

-Хэнтий аймгийн, нутгийнхаа ямар ямар хийдийн тухай мэдэх вэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Балданбэрээвэнд хурал нь хурж цам нь гарч байхад нэг удаа очсон юм. Тэр нь хамгийн сүүлийн цам байсан байх. Сүүлд 1990 оноос дуган барьж хурал сэргээлээ гээд нэг өвгөн лам байсан. Тэгэхэд би очиж хоёр унтсан юм. Сахиусаа тахиулъя гээд.

Балданбэрээвэн гэдэг чинь том хийд байсан. Ар утай гэдэг нэртэй. 1000-аад лам байсан. Энэ дотор багтаж л байсан юм гэж хөгшчүүл ярьдаг байсан. Цогчэн, Чойр, Жүд, Манба, Дүйнхор гэсэн 14 дугантай байсан. Манзшир бурхан бий. Хаданд сийлсэн. Бэрээвэнгийн хаданд сийлсэн соёмбо бий. Тэгж хаданд соёмбо сийлсэнээс болж лам хөөгдсөн. Төргүй газар шашин байхгүй. Төрийн хараанд шашин үйлчлэх ёстой төрийн сүлдийг энд залснаар бид буруудахгүй. Миний сүлд Бэрээвэнг нохой урсан адсага адил болоход хэвээрээ гялалзаж байх болно гэж хэлээд хөөгдсөн.

- Бэрээвэнд байсан Тантан жалбын хурал, Тантагийн хурал хоёр өөр юм уу?

Өөр. Энэ хоёр бол дуган. Тантанд дандаа хүүхнүүд хурдаг. Тантан жалбын хурал гэдэг нь Цогчэн энэ тэрээ бүгдийгээ хамт уншчихаад тэгээд лүйжингээ унших болохоор хүүхнүүд нь яваад өгдөг тийм хурал. Тэгээд лам нар нь хурдаг. Тантан нь Бэрээвнээсээ баруун хойшоо байдаг байсан. Тантан жалбын хурал гэдэг нь Бэрээвэнгийн горломон дотроо байдаг байсан.

-Бэрээвэнгийн тэр хавьд Шарилын хурал гэж байсан уу?

Байхгүй. Хутагтын хүрээ гэж байна. Хутагтын хүрээнийхээ хойно тусдаа Тантангийн хурал гэж байсан. Тантангийн хурлаас хойш Шарилын хурал гэдэг чинь дээшээгээ байсан юм. Тийм л юм гэж би дуулснаа л хэлж байгаа юм. Тэрнээс биш миний мэдэх гэж юу байхав. Лам настай өвгөчүүлтэй хууч хөөрч байхад тэгж л дуулж байсан юм. Тэд маань надад үнэн хэлж байгаа бол би үнэнийг л хэлж байгаа. Тэд худлаа хэлж байсан бол худлаа л хэлж байгаа.

-Мөрөн сумд харъяалагдах Суварганы хийд, Хурц ламын хийд гэдгийн түүрийг үзсэн.

Хурц ламын хийд гэдэг чинь Өндөрхааны зүүхэн талд байгаа. Суварганы хийд гэдэг нь Номт баяныхаа өвөрт байгаа хийд байхгүй юу.

- Суварганы хийд, Хурц ламын хийд хоёр нэг хийд юм байна?

Нэггүй. Тусдаа хийд шүү. Суварганы хийд гэдэг чинь Өндөрхааныхаа зүүн талд бүр дээр ууландаа. Үзэхгүй бол болохгүй. Тун үзмээр газар байгаа.

- Номт баян гэдэг нь ямар газрын нэр юм?

Уулын нэр байхаа. Суварганы хийд гэдэг нь Номт баяныхаа өвөрт байгаа хийд байхгүй юу.

- Пунцаглин хийд гэж Хэрээ Хөхөлийн хийд юм байна?

Тийм Хэрээ Хөхөлийн хийд. Нутгийн хүмүүс Хөхөл Хайрханы хийд гэж нэрлэдэг юм. Тэр нэрээр нь нэрлээд хийдийг нь оруулах хэрэгтэй. Голынхоо урд талд дээр нь суварга босгочихсон.

-Мөрөн сумын Замбилан хийд гэж ямар хийд байсан юм бол? Нарийн овоо гэдэг газар байдаг?

Мэдэхгүй. Ёстой дуулаагүй юм байна.

-Нарийн овоо гэдэг газрыг та мэдэх үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хэн мэдэхэв. Мэдэхгүй.

-Бас Хөндлөнгийн шүтээн гэж байгаа? Улаан овоо гэдэг газар байдаг?

Дуулаагүй л юм байна.

-Гүнгийн шүтээн гэж байна?

Гүнгийн шүтээн гэдэг чинь энэ хойшоо Өндөрхааны зүүн хойно байгаа.

-Хэр том хурлын газар байсан юм бол?

Жаахан. Цөөхөн лам нартай. Эрх ахайгаас Ганжуур, Данжуур гуйж хурдаг тийм газар байсан.

-Бүсийн шүтээн гэж?

Бүсийн шүтээн гэдэг нь одоо голынхоо хойд талаар дээшээ явахаар байдаг байсан.

-Мөрөн сум, Өндөрхаан хавиар энд ороогүй хийд байна уу?

Байхгүй байна аа. Хэрлэн сумыхад бол зүүн урагш хоёр хийд байсан. Тэр ороогүй байна. Хэрлэнгийн хийд, Сэргэлэнгийн хийд гэж.

-Энэ хоёр хийд маань Идэрмэгт орох уу?

Тэгнэ. Сүжигт бэйсийн хийд гэж байсан.

-Идэрмэгт Лүнгийд хийд гэж байна. Тэр тухай мэдэх үү?

Мэдэхгүй ээ. Та нар ийшээ яваад Баян-Овоод очих үү?

-Тэгнэ.

Тэнд ямар хийд байна?

-Зүүн Гуутын хийд гэж байна. Голынхоо урд. Жавхлантын хийд гэж байсан байна.

Одоо сумын төв байгаа газар.

-Далтын шүтээн гэж байсан байна?

Далтын шүтээн ээ?

Баян-Овоогоосоо зүүн тийш байсан байна.

За одоо миний мэддэг ч боллоо доо.

-Мөрөнгийн Замилан гэдэг чинь Жаргалтхааны Гичгэний хойно байгаа юм. Тэнд бид нэг туурь үзсэн. Жаргалтхааны Чулуут баг руу явж байсан юм. Улаан худаг гэдэг газар байсан. Ар талынх нь уул нь Дашбалжир гэдэг уул. Энэ одоо ямар нэртэй хийд болох талаар танд хэлэх юм байна уу?

Тэрийг сайн мэдэхгүй байна. Газрынх нь нэг нэрийг тавьчихад буруудах юм байхгүй дээ. Улаан худгийнх юм уу, Дашбалжирийнх гээд аль нэгээр нь хэлэхэд л болно.

-Өлзий сангийн аж ахуйн тэнд Бүстийн шүтээн гэж байна. Энэ одоо хаана байсан юм бол?

Тэнд шүтээн гэж байсан юм уу? Би мэдэхгүй юм байна. Дуулаагүй л юм байна.